



РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын “Радио, телевизийн газрын сүлжээний технологийн үйл ажиллагаанд хяналт хийх, шуурхай удирдлагаар хангах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мөрдүүлж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Ц.Ганзориг)-т, Техникийн бодлого, төлөвлөлтийн газар (Д.Галбадрах)-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан захирлын 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ



Б. ДАГВАСҮМБЭРЭЛ

1624010054



РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ХИЙХ, ШУУРХАЙ УДИРДЛАГААР ХАНГАХ ЖУРАМ

БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь радио, телевизийн газрын сүлжээний /цаашид “сүлжээ” гэх/ ашиглалт, үйлчилгээний байнгын, тасралтгүй, найдвартай ажиллагааг хянаж салбар, станц, орон нутгийн газруудыг өдөр тутмын технологийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахад чиглэнэ.
- 1.2 Радио, телевизийн газрын сүлжээний бүрэлдэхүүн хэсгүүдийн /цаашид “салбар” гэх/ технологийн үйл ажиллагаанд хяналт хийх, нэгдсэн шуурхай удирдлагаар хангах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.
- 1.3 Энэхүү журмыг “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын /цаашид “үйлдвэрийн газар” гэх/ салбарууд үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 1.4 Үйл ажиллагаандаа төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP систем, shua_rtv@rtbn.gov.mn төрийн байгууллагын цахим шуудан, 75112020 албаны телефон утас, 99900362, 97074040 гар утас болон дотоодын хэрэглээний холболтын сүлжээг тус тус ашиглана.

БҮЛЭГ 2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1 “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ” гэж радио давтамж ашиглан сүлжээ байгуулж, хэрэглэгч хүлээн авах төхөөрөмж ашиглан радио, телевизийн үйлчилгээг тодорхой хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авах боломжоор хангах үйлчилгээг;
 - 2.2 “Сүлжээний ашиглалт” гэж сүлжээний тогтвортой ажиллагааг хангахад чиглэсэн засвар, хэмжилт, тохируулга хийх үйл ажиллагааг;
 - 2.3 “Шуурхай удирдлага” гэж сүлжээний үйл ажиллагаанд байнгын хяналт, зохицуулалт хийж, ажлын бус цагаар шуурхай ажиллагааны үеийн үйл ажиллагааг технологийн өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллахыг;
 - 2.4 “Сүлжээний харилцан холболт” гэж гэрээний үндсэн дээр холбогдсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сүлжээ болон үйлдвэрийн газрын сүлжээ хоорондын харилцан холболтыг;
 - 2.5 “Техникийн ашиглалт үйлчилгээний зааглах цэг” гэж сүлжээний техник төхөөрөмжийн салбаруудад харьяалах холболтын цэгийг;
 - 2.6 “Салбарууд” гэж үйлдвэрийн газрын бүтцийн бүрэлдэхүүнд ордог дор дурдсан газар, станц, алба, төвийг;

- Баян-Өлгий РТСГ
- Говь-Алтай РТСГ
- Дорнод РТСГ
- Өмнөговь РТСГ
- Хөвсгөл РТСГ
- Радио нэвтрүүлэх төв станц
- Телевизийн төв станц
- Хотын шугамын радиогийн алба
- Хэмжилт, засварын алба

2.7 "Олон нийтийн радио, телевиз" гэж Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан зөвхөн олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус радио, телевизийн үйлчилгээг;

2.8 "Өргөн нэвтрүүлгийн радио, телевиз" гэж олон талт хөтөлбөртэй, радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ болон олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр заавал дамжих арилжааны радио, телевизийн үйлчилгээг;

БҮЛЭГ 3. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

3.1 Үйлдвэрийн газрын радио, телевизийн газрын сүлжээний технологийн үйл ажиллагааг байнгын, тасралтгүй горимоор хяналт хийх, салбаруудыг шуурхай удирдлагаар хангах үйл ажиллагааг Шуурхай удирдлагын алба хариуцна.

3.2 Засвар үйлчилгээгээр ажиллах инженер техникийн ажилчдыг найдвартай унаа машин, шаардлагатай сэлбэг материал, бусад хэрэгслээр хангах үйл ажиллагааг Аж ахуй үйлчилгээний хэлтэс болон тухайн салбар нэгж хариуцна.

3.3 Гэмтэл саатлын үед мөрдөх "Хяналтын хугацаа" болон "Сүлжээний харилцан холболтын цэг", салбаруудын "Техникийн ашиглалт үйлчилгээний зааглах цэг"-ийг өөрчлөлт орсон тухай бүр Техник ашиглалтын хэлтэс шинэчлэн боловсруулж, батлуулж мөрдүүлнэ.

3.4 Зайлшгүй шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж хэмжилт, засвар үйлчилгээг хийх ажлыг Техник ашиглалтын хэлтэс зохион байгуулна.

3.5 Байгалийн бэрхшээл, эрчим хүчний гэмтэл, тоног төхөөрөмжийн гэмтэл зэргээс шалтгаалан сүлжээний хэвийн байдал алдагдаж хэрэглэгчийн үйлчилгээ удаан хугацаагаар саатах тохиолдолд "Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ын 4.11-д заасны дагуу гэмтэл гарсан шалтгаан, гэмтлийн хамрах хүрээ зэрэг мэдээллийг Техник ашиглалтын хэлтсээс Харилцаа холбооны зохицуулах хороо болон Монголын үндэсний олон нийтийн радио, телевизд 20 минутад багтаан мэдээлнэ.

3.6 Сүлжээний тоног төхөөрөмжид графикт засвар, үйлчилгээ хийх болон Цахилгаан түгээх сүлжээний газраас урьдчилан мэдэгдсэн удаан хугацааны эрчим хүчний саатлын талаарх мэдээллийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизд Техникийн бодлого, төлөвлөлтийн газраас урьдчилан мэдэгдэнэ.

3.7 Үзэгч, сонсогчоос ирсэн гомдол саналыг барагдуулахад "Радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээний талаар өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам"-ыг мөрдөнө.

3.8 Баяр ёслол нийтээр амрах амралтын өдрүүдэд Захирлын тушаалаар томилогдсон салбаруудын комисс нь сүлжээний ажиллагааны мэдээг шуурхай удирдлагад тогтмол мэдээлэх ба шуурхай удирдлагаас байгууллагын ерөнхий комисст тайлагнана.

БҮЛЭГ 4. СҮЛЖЭЭНИЙ ХЯНАЛТ УДИРДЛАГА

4.1 Сүлжээний хяналт, шуурхай удирдлагыг дараах чиглэлээр хийнэ.

- 4.1.1 Сүлжээний хиймэл дагуулаас хүлээн авч байгаа телевиз, радиогийн програмуудыг хянаж, чанарын шаардлага хангасан программ хүлээн авах талаар Монголсат нетворкс ХХК-ийн инженерүүд, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хяналтын алба, Өргөн нэвтрүүлгийн радио, телевизүүдэд шаардлага тавьж, гэмтэл саатал гарсан тохиолдолд ээлжийн инженер техникийн ажилтан нартай гарсан гэмтэл саатлын цаг хугацаа, шалтгааныг тохирно.
- 4.1.2 Гэмтэл саатлын шинж чанар, шалтгаан нөхцөлөөс шалтгаалж Хэмжилт, засварын албаны болон аймгийн мэргэжлийн инженерээр зөвлөгөө өгүүлэх, зайнаас хандаж ажиллуулах, засварын баг ажиллуулах, мөн бусад мэргэжлийн байгууллагад хандаж гэмтэл саатлыг арилгах арга хэмжээг авч ажиллана.
- 4.1.3 Ажлын бус цагаар гэмтэл саатал гарсан үед томилолтоор ажиллах инженер техникийн ажилтан, жолооч нарт ХАБЭА-н ээлжит бус зааварчилгааг амаар болон бичгээр өгнө. Бичгээр өгсөн тохиолдолд гарын үсгийг зуруулж, анхан шатны бүртгэлд тэмдэглэнэ.
- 4.1.4 Илүү цагаар ажилласан ажилтан, албан хаагчдын цагийг анхан шатны бүртгэлд бүртгэх ба цаг агаарын онцгой хүнд нөхцөлд томилолтоор ажиллуулахыг хориглоно.
- 4.1.5 Шаардлагатай тохиолдолд салбар, удирдлагаас томилсон засварын баг нь хяналтын хугацаанд багтааж ажилд гаргана. Засварын багийн ахлагч нь ажлын талбарт очсон, ажил гүйцэтгэж эхэлсэн, дууссан цаг, ажлын явц, зарцуулсан сэлбэг материал, хэрхэн засварласан талаар Шуурхай удирдлагын инженер тухай бүрт заавал мэдээлж ажиллана. Өгсөн мэдээллийг бүртгэж, холбогдох арга хэмжээг авч, шаардлагатай тохиолдолд удирдлагад мэдээлж, удирдлагаас өгсөн зааврын дагуу ажиллана.
- 4.1.6 Сүлжээнд гэмтэл саатал гарч, удаан хугацаагаар нэвтрүүлэг саатах, ашиглалтын болон хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журам зөрчигдсөн, аваар осол гарсан зэрэг нөхцөлд салбарын удирдлага, хариуцсан ажилтантай холбогдож авч байгаа арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар газрын удирдлагад тухай бүр мэдээлэх ба удирдлагаас өгсөн удирдамжийн дагуу ашиглалтад гарсан онцгой яаралтай асуудлыг шуурхай арга хэмжээ авч шийдвэрлэх талаар холбогдох салбар нэгжийн удирдлагад үүрэг даалгавар өгч ажиллана.
- 4.1.7 Гэмтэл саатлыг “Хяналтын хугацаа”-нд багтаан засварлуулах арга хэмжээг авч ажиллах ба хугацаа хэтэрсэн гэмтэл, саатлын шалтгаан, цагийг тодорхойлж анхан шатны бүртгэлд бүртгэнэ.

- 4.1.8 Түлхүүрийг бүртгэлийн дэвтэрт өгсөн, авсан цаг, шалтгааныг бичиж хяналт тавьж ажиллана. Гаднын байгууллагын өөрийн төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийх, шинээр төхөөрөмж суурилуулах хүсэлт, техникийн нөхцөлийг үндэслэн сайтад нэвтрүүлэх зөвшөөрлийг олгож, түлхүүрийг өгнө. Шаардлагатай тохиолдолд хоногийн ажиллагааны мэдээнд оруулж танилцуулна.
- 4.1.9 Техник тоног төхөөрөмжийн ажиллаж байгаа давтамжийн хуваарь, хүчин чадал, сүлжээний удирдлага хяналтын системийн нууц код, түлхүүр, паспорт сүлжээний схем, сүлжээний зураглал, холбох хэрэгслийн сүлжээний өгөгдлүүд зэрэг холбооны нууцыг хамгаална.
- 4.2 Сүлжээний ажиллагааны мэдээг хүлээн авч боловсруулж, тайлагнана.
- 4.2.1 Сүлжээний хоногийн ажиллагааны мэдээг салбаруудаас shua_rtv@rtbn.gov.mn и-мэйл болон ERP системээр дараах хуваарийн дагуу авна.
- Хэмжилт засварын албаны ашиглалтын инженерүүдээс ажлын өдөр 16:30-17:00 цагт
 - Хотын шугамын радиогийн албаны ээлжийн оператороос ажлын өдөр 16:30-17:00 цагт
 - Орон нутгийн тоон телевизийн инженерүүдээс ажлын өдөр 09:00-11:00 цагт
 - Салбар станцуудаас хоногийн ажиллагааны мэдээг өдөр бүр 06:30-07:30 цагт
- 4.2.2 Сүлжээний болон байгууллага, салбарын хэвийн ажиллагаа алдагдаж эрсдэл гарах нөхцөл үүссэн үед салбарууд нь гэмтлийн шалтгаан, эхэлсэн цаг, авсан арга хэмжээ, зарцуулсан сэлбэг материал, гэмтэл, саатал хаагдсан талаар мэдээллийг цаг харгалзахгүй үнэн зөв мэдээлнэ.
- 4.2.3 Авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, сүлжээнд доголдол үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон үед удирдлагад яаралтай мэдэгдэж, доголдлыг арилгах, эрсдэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээг холбогдох газруудтай хамтран шуурхай зохион байгуулна.
- 4.2.4 Хяналтын хугацаа хэтэрсэн гэмтлийг өглөөний шуурхай хуралд мэдээлнэ. Техникийн зөвлөл, Техник ашиглалтын хэлтсээс хяналтын хугацаа хэтэрсэн шалтгааныг тогтоож ямар арга хэмжээ авах талаар шийдвэр гаргана.
- 4.2.5 Сүлжээний хоногийн ажиллагааны байдал, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, асуудал шийдвэрлэсэн, байгууллагын ерөнхий ажиллагааны мэдээллийг хоногийн ажиллагааны мэдээнд бүрэн тусгаж, батлагдсан маягтын дагуу нэгтгэж, өдөр бүр 08:00 цагт ERP системийн “Мессенжер”-т байршуулж, ажлын өдөр бүр 08:15 цагт өглөөний шуурхай хуралд мэдээлнэ.
- 4.2.6 Шуурхай хурлыг Техник ашиглалтын хэлтсийн дарга удирдаж, шуурхай хурлын үүрэг даалгавар, гэмтэл саатлын талаарх шийдвэрийг гаргана.
- 4.2.7 Шуурхай хурлаас гарсан шийдвэр, цаашид авах арга хэмжээ, шийдвэрлэх хугацааг хариуцах салбар, ажилтанд танилцуулна. Мөн шуурхай хурлын шийдвэр, үүрэг даалгаварыг хоногийн ажиллагааны мэдээнд нэмж тусган ERP системийн “Файлын сан”-д байршуулж үйлдвэрийн газрын удирдлагад танилцуулна.
- 4.2.8 Хугацаат үүрэг даалгаврын биелэлтийн явцыг сар бүр гаргаж, сарын эхний өдөр өглөөний шуурхайд танилцуулна. Гэмтэлтэй төхөөрөмжийн мэдээллийг пүрэв гараг бүрт нэгтгэн шинэчилж, хоногийн ажиллагааны мэдээнд оруулна.

4.2.9 Монголсат нэтворкс ХХК-ийн телевизийн нэвтрүүлэг дамжуулсан цагийн мэдээг сар бүрийн 15-ны өдөр нэгтгэн Техникийн бодлого, төлөвлөлтийн газар, Техник ашиглалтын хэлтэст тус тус өгнө.

4.2.10 Дараах хяналтыг графикт хугацаанд хийж, үйлдвэрийн газрын удирдлагад бичгээр тайлагнана.

- Орон нутгийн операторуудтай жилд 1 удаа шууд холбогдож авсан сүлжээний ажиллагааны хяналт
- Хяналтын хэрэглэгчдээс урт, богино долгион, ФМ105.5, ФМ89.9 станцуудад хийсэн хяналт
- Шуурхай хурлын ирцийн бүртгэлийн хяналт
- Шуурхай ажиллагааны үеийн утсанд хариу өгөлтийн хяналт

4.2.11 Шуурхай удирдлагын алба болон салбарууд сүлжээний хяналтыг тасралтгүй хийж дараах бүртгэлүүдийг хөтөлж, сар, улирал, жилээр нэгтгэн тайланг гаргана.

- Хоногийн ажиллагааны мэдээ
- Гэмтэлтэй тоног төхөөрөмжийн мэдээ
- Хяналтын хугацаа хэтэрсэн саатлын мэдээ
- Хяналтын хугацаа хэтэрсэн гэмтлийн мэдээ
- Телевизийн саатлын мэдээ салбар болон аймгаар
- Радио өргөн нэвтрүүлгийн саатлын мэдээ салбар болон аймгаар
- ФМ нэвтрүүлгийн саатлын мэдээ салбар болон аймгаар
- Гомдол саналын мэдээ
- Графикт техникийн үзлэг хийсэн мэдээ
- Томилолтоор болон ажлын бус цагаар ажилласан ажилтны бүртгэл
- Телевизийн чанарын сарын мэдээ
- Радио өргөн нэвтүүлгийн чанарын сарын мэдээ
- Монголсат нетворкс ХХК-ны нэвтрүүлэг дамжуулсан цагийн тооцоо
- Үүрэг даалгаврын бүртгэл
- Мэдээ өгөлт, шуурхай хуралд оролцсон ажилтнуудын бүртгэл
- Станцын тоног төхөөрөмжид үзлэг, үйлчилгээ хийсэн бүртгэл
- Сайтад нэвтрэх хүсэлтийн бүртгэл
- Салбар нэгжүүдийн мэдээ өгөлтийн бүртгэл
- ХАБЭА-н 1-р шатны хяналтын бүртгэл
- ХАБ-ны ээлжит бус зааварчилгааны бүртгэл
- Жолоочийн ажлын байрны зааварчилгааны бүртгэл
- ХШРА-ны гэмтэл хүлээн авах журнал
- Операторуудын бүртгэл
- Хяналтын хэрэглэгчдийн бүртгэл
- Бэлэн мөнгөний бүртгэл

БҮЛЭГ 5. ЧАНАРЫН МЭДЭЭ, ТАЙЛАН

5.1 Радио телевизийн сүлжээний дамжуулалтын чанар, ажиллагааны найдвартай байдалд сар, улирал, жилээр үнэлэлт өгч холбогдох мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах, гэмтэл саатлын шинж чанар, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ

хийж давтан гаргахгүй байхад чиглэсэн оновчтой шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2 Ашиглалтыг боловсронгуй болгох, чанарын үзүүлэлтийг сайжруулах, шинэ техник технологи нэвтрүүлэхтэй холбогдсон техник зохион байгуулалтын ажлыг байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

5.3 Чанарын мэдээ тайланг сар, улирал, жилээр нэгтгэн гаргаж, илтгэх хуудсаар үйлдвэрийн газрын удирдлагад танилцуулна.

5.4 Радио, телевизийн нэвтрүүлгийн дамжуулалтын чанарын төлөвлөгөөг сүлжээний тасралтгүй ажиллагааны түвшин /ТАТ/ улирал бүр 99,8%-иас доошгүй байхаар тооцон салбар бүрээр Техник ашиглалтын хэлтэс гаргаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

БҮЛЭГ 6. СҮЛЖЭЭНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

6.1 Тоон телевизийн газрын сүлжээ:

| Салбар | Станцын тоо | Хамрах станц | |
|-----------------------|-------------|--|---|
| Хэмжилт, засварын төв | Архангай | 19 | Бүх сум |
| | Өвөрхангай | 20 | Бүх сум |
| | Булган | 4 | Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант |
| | Төв | 21 | Нийт 27 сумтай: Алтанбулаг сум станцгүй. Мөнгөнморьт, Баяндэлгэр, Эрдэнэ, Архуст, Сүмбэр сумаас бусад сум |
| | Хот орчим | 12 | Гачуурт |
| | | | Биокомбинат |
| | | | Өлзийт |
| | | | Бэлх |
| | | | Партизан |
| | | | Баянхошуу |
| | | | 61-н гарам |
| | | | Хүрэлтогоот |
| | | | Нисэх |
| Налайх | | | |
| Багахангай | | | |
| Тэрэлж | | | |
| Булган | 13 | Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант сумдаас бусад 13 сум | |
| Орхон | 3 | Баян-Өндөр, Жаргалант, Говил | |
| Дархан | 13 | Дархан-Уул, Шарын гол, Номгон, Хөтөл, Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Шарус, Баруунхараа, Зүүнхараа, Түнхэл, Төв аймгийн Сүмбэр сум | |
| Сэлэнгэ | 11 | Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Дулаанхаан, Жавхлан, Ерөө, Бугант, Хүдэр, Орхон жимс | |

| | | | |
|-----------------|------------|------------|--|
| | Хэнтий | 20 | Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумдаас бусад |
| | Багануур | 8 | Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, Эрдэнэ, Архуст сумд, Багануур, Булагтай, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Хэрлэнбаян-Улаан сумд |
| | Дорноговь | 18 | Дорноговь-15 сум, Говь-сүмбэр-3 сум |
| Говь-Алтай РТСГ | Говь-Алтай | 20 | Бүх сум |
| | Баянхонгор | 21 | Бүх сум |
| Баян-Өлгий РТСГ | Баян-Өлгий | 15 | Бүх сум |
| | Ховд | 17 | Бүх сум |
| | Увс | 20 | Бүх сум |
| Өмнөговь РТСГ | Өмнөговь | 14 | Бүх сум |
| | Дундговь | 15 | Бүх сум |
| Дорнод РТСГ | Дорнод | 13 | Бүх сум |
| | Сүхбаатар | 13 | Бүх сум |
| Хөвсгөл РТСГ | Хөвсгөл | 24 | Бүх сум |
| | Завхан | 24 | Бүх сум |
| ТТС | ТТС | 1 | |
| | Чингэлтэй | 1 | |
| Нийт станц | | 360 | |

6.2 Радио өргөн нэвтрүүлгийн газрын сүлжээ

| Салбар | | Станц | Станцын тоо |
|----------------------------|-----------------------|----------|-------------|
| Радио нэвтрүүлэх төв станц | | ДСВ500 | 1 |
| | | ПКВ250 | 1 |
| | | NEC50 | 1 |
| Баян-Өлгий РТСГ | Баян-Өлгий-Өлгий | TRAM150L | 1 |
| | Баян-Өлгий-Өлгий | FM107.0 | 1 |
| | Ховд-Жаргалант | FM105.5 | 1 |
| | Увс-Улаангом | FM105.5 | 1 |
| | Увс-Баруунтуруун шад | FM105.5 | 1 |
| Говь-Алтай РТСГ | Говь-Алтай-Есөнбулаг | ДСВ150 | 1 |
| | Говь-Алтай-Есөнбулаг | NEC10 | 1 |
| | Говь-Алтай-Есөнбулаг | FM105.5 | 1 |
| | Баянхонгор-Баянхонгор | FM105.5 | 1 |
| Дорнод РТСГ | Дорнод-Хэрлэн | ДСВ150 | 1 |
| | Дорнод-Хэрлэн | ПСВ1000 | 1 |
| | Дорнод-Хэрлэн | FM105.5 | 1 |
| | Дорнод-Хэрлэн | FM106.7 | 1 |
| | Сүхбаатар-Баруун-Урт | FM105.5 | 1 |
| Өмнөговь РТСГ | Өмнөговь-Даланзадгад | ДСВ150 | 1 |
| | Өмнөговь-Даланзадгад | FM105.5 | 1 |
| | Дундговь-Мандалговь | FM105.5 | 1 |
| | Хөвсгөл-Мөрөн | ДСВ150 | 1 |

| | | | |
|---------------------------------|------------------------------------|--------------|----|
| Хөвсгөл РТСГ | Хөвсгөл-Мөрөн | NEC10 | 1 |
| | Хөвсгөл-Мөрөн | FM105.5 | 1 |
| | Хөвсгөл-Мөрөн | FM103.0 | 1 |
| | Хөвсгөл-Цагаан-Үүр | FM105.5 | 1 |
| | Завхан-Улиастай | FM105.5 | 1 |
| | Завхан-Тосонцэнгэл | FM105.5 | 1 |
| Хэмжилт, засварын төв | Улаанбаатар-Налайх | FM105.5 | 1 |
| | Улаанбаатар-Багануур | FM105.5 | 1 |
| | Төв-Зуунмод | FM105.5 | 1 |
| | Төв-Эрдэнэ | FM105.5 | 1 |
| | Архангай-Эрдэнэбулган | FM105.5 | 1 |
| | Өвөрхангай-Арвайхээр | FM105.5 | 1 |
| | Дорноговь-Сайншанд | FM105.5 | 1 |
| | Дорноговь-Замын-Үүд | FM105.5 | 1 |
| | Говьсүмбэр-Чойр | FM105.5 | 1 |
| | Дархан-Уул-Дархан | FM105.5 | 1 |
| | Дархан-Уул-Шарынгол | FM105.5 | 1 |
| | Орхон-Баян-Өндөр | FM105.5 | 1 |
| | Булган-Булган | FM105.5 | 1 |
| | Сэлэнгэ-Сүхбаатар | FM105.5 | 1 |
| | Сэлэнгэ-Зүүнхараа | FM105.5 | 1 |
| | Хэнтий-Чингис | FM105.5 | 1 |
| Хэнтий-Цэнхэрмандал | FM105.5 | 1 | |
| Телевизийн төв станц | Улаанбаатар-ТТС | FM106.0 | 1 |
| | Улаанбаатар-ТТС | FM100.9 | 1 |
| | Улаанбаатар-ТТС | FM103.1 | 1 |
| Хотын шугамын радио зангилаа | УБ-Төв радио зангилаа | Енисей5кВт | 1 |
| | СХД-н радио зангилаа | Енисей5кВт | 1 |
| | БЗД-н радио зангилаа | Енисей5кВт | 1 |
| | БГД-н радио зангилаа | Енисей5кВт | 1 |
| | Нисэх радио зангилаа | Енисей1,5кВт | 1 |
| | Орхон-Баян-Өндөр радио зангилаа | Енисей5кВт | 1 |
| Нийт станц | | | 53 |

БҮЛЭГ 7. БУСАД

7.1 Энэхүү журмыг баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.

7.2 Шаардлагатай бол журамд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

БҮЛЭГ 8. Хариуцлага

8.1 Журмыг зөрчсөн тохиолдолд тухайн салбарын удирдлага, ажилтан, инженер техникийн ажилтнууд хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль, дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.